



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/12/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Даланзадгад хот 2022 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК</p> <p>Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Сурагчдын сэтгэл зүйг шинэ орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлж сурлагын хоцрогдлыг арилгахад оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр хүүхдийн сурах үйл оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах;
- Сургуулийн үйл ажиллагаа хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан бие даах болон хамтран суралцах арга барилд суралцах үйлд дэмжлэг үзүүлэх;
- Сурагч бүрийг нийгэм сэтгэл зүйн хувьд эрүүл аюулгүй орчинд амьдрах, шинэ орчин, нөхцөлд дасан зохицох, зөв дадал хэвшилтэй болгох сэтгэл зүйн бэлтгэлд төлөвшүүлэх;
- Багшид үзүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцааг үзүүлэн, суралцах идэвхитэй үйлийг дэмжсэн арга зүйг хөгжүүлэхэд чиглүүлэх;

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчаас үнэ төлбөргүй балансаас балансад 1,648,775.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг авснаар үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.2 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:



Аудитаар нийт 14,290.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 1,043.9 мянган төгрөгийн 1 зөрчлийн алдааг залруулсан, зөрчлийг арилгах 13,246.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын ерөнхий боловсролын сургууль	5	14,290.7	1	1,043.9			1	-	3	13,246.8